

Испани маягаар шарсан утсан хиамтай төмс

Орц

- 4 хүний порц
 - 1,2 кг төмс
 - 250 гр утсан хиам/ Нарийн утсан хиам: Аянчин ч юм уу/
 - 1 улаан халуун чинжүү
 - 8 ширхэг жижиг хүрэн сонгино
 - 2-3 х/халбага оливын тос
 - 1 боодол ногоон сонгино
 - Давс перец

Заавар

- 1 1. Төмсөө 20 минут чанана. Хиамаа хальслаад дугуй хэлбэртэй хэрчинэ. Чинжүүгээ цэвэрлээд нарийн дугуй хэлбэртэй зүснэ. Хүрэн сонгиноо цагираг хэлбэртэй зүснэ.
 - 2. Чанасан төмсөө хүйтэн усанд сойно. Дугуй хэлбэртэй зүснэ.
 - 3. Том хайруулын тавганд оливын тосоо хийж халаана. Хиамаа хийж шарна. Төмсөө 10 минут шаргал өнгөтэй болтол нь шарна. 5 минутын дараа сонгино чинжүүгээ хийж шарна.
 - 4. Ногоон сонгиноо цагираг хэлбэртэй татна. Шарсан төмсөн дээрээ давс перецний хамт цацна.
- Сайхан хоолоорой! Buen apetito!

